**ХӨВСГӨЛ АЙМГИЙН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 12 сарын 03 өдөр　　　　Дугаар А/97　　　　Мөрөн

Аймгийн хэмжээнд 2020-2021 онд эмнэлгийн тусламж
үйлчилгээнд ашиглах орны дээд хязгаар батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/479 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн эрүүл мэндийн салбарт 2020-2021 онуудад сумдын эмнэлгийн хэмжээнд ашиглагдах орны дээд хязгаарыг 1 дүгээр, Аймгийн төвийн хэмжээнд ашиглагдах орны дээд хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Орны дээд хязгаарт багтаан үйл ажиллагаагаа төлөвлөн, төсвийн төлөвлөлтийг хийж, батлуулж, эмнэлгийн орны ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагуудын дарга болон Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн удирдлагын хэлтсийн дарга, эдийн засагч (Б.Батчимэг) нарт үүрэг болгосугай.

3. Аймгийн хэмжээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад орны ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт хийж, тусгай зөвшөөрлийн хуралд тухай бүр нь танилцуулж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга (М.Энхдалай)-д, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Хуулийн зөвлөх (Х.Баттогтох)-д тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбоотой Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/63 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА　　　　М.ҮҮРИЙНБАЯР

D:\Desktop\tushaal\2019-a.docx

35110437

Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны
12 дугаар сарын 03-ны өдрийн А/97
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН СУМДЫН ХЭМЖЭЭНД 2020-2021 ОНД АШИГЛАГДАХ ЭМНЭЛГИЙН ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

| Бүтэц үйл ажиллагааны стандартын дагуу MNS 5081:2013 | Сумдын нэрс | Аймгийнт өв СЭМТ-ийн хоорондох зай | СЭМТөвөөс аймгийн төв хүртэлх машинаар зорчиход зарцуулах хугацаа / цагаар/ | Үйлчлэх хүрээний хүн амын тоо | Өдрийн эмчилгээний ор | Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний ор | | | Нийт орны дээд хязгаар | Эхчүүдийн амрах байрны орны тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эмнэл зүйн эрт үеийн эмнэлгийн цогцт усламж, үйлчилгээний ор | Үүнээс | | | |
| | | | | | | | Өвчний хурц /цочмог/ үеийн ор | Өвчний хурцавтар /цочмогдуу/ үеийн ор | | |
| СЭМТ Б ангилал буюу 2-р зэрэглэл /Аймгийн төвөөс 50-99 км-ийн зайтай ба 1-2 цагийн хооронд хугацаанд зорчих/ | Түнэл сумын эрүүл мэндийн төв | 46 | 1.00 | 3827 | 2 | 6 | 5 | 1 | 8 | 2 |
| | Алаг-Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв | 63 | 1.30 | 3076 | 2 | 6 | 5 | 1 | 8 | 2 |
| | Арбулаг сумын эрүүл мэндийн төв | 71 | 1.30 | 3952 | 2 | 8 | 7 | 1 | 10 | 2 |
| | Бүрэнтогтох сумын эрүүл мэндийн төв | 51 | 1.10 | 4113 | 2 | 6 | 5 | 1 | 8 | 2 |
| | Тосонцэнгэл сумын эрүүл мэндийн төв | 64 | 1.40 | 4047 | 2 | 7 | 6 | 1 | 9 | 2 |
| | Төмөрбулаг сумын эрүүл мэндийн төв | 73 | 2.30 | 4238 | 2 | 10 | 9 | 1 | 12 | 2 |
| СЭМТ В ангилал /Аймгийн төвөөс 100 км-ээс хол, 2 цагаас дээш | Баянзүрх сумын эрүүл мэндийн төв | 127 | 4.00 | 3922 | 2 | 13 | 10 | 3 | 15 | 2 |
| | Галт сумын эрүүл мэндийн төв | 167 | 4.30 | 5194 | 2 | 20 | 16 | 4 | 22 | 3 |
| | Жаргалант сумын эрүүл мэндийн төв | 177 | 6.00 | 5181 | 2 | 17 | 14 | 3 | 19 | 3 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хугацаанд зорчих/ | Рашаант сумын эрүүл мэндийн төв | 130 | 6.00 | 3662 | 2 | 12 | 9 | 3 | 14 | 2 |
| | Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төв | 243 | 10.00 | 4841 | 2 | 19 | 16 | 3 | 21 | 3 |
| | Тариалан сумын эрүүл мэндийн төв | 160 | 5.00 | 5753 | 2 | 21 | 18 | 3 | 23 | 3 |
| | Ханх сумын эрүүл мэндийн төв | 281 | 16.00 | 2631 | 2 | 13 | 10 | 3 | 15 | 2 |
| | Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төв | 173 | 8.00 | 2509 | 2 | 11 | 8 | 3 | 13 | 2 |
| | Цэцэрлэг сумын эрүүл мэндийн төв | 209 | 8.00 | 4734 | 2 | 18 | 14 | 4 | 20 | 3 |
| | Чандмана-Өндөр сумын эрүүл мэндийн төв | 137 | 6.00 | 3012 | 2 | 12 | 9 | 3 | 14 | 2 |
| | Цагааннуур сумын эрүүл мэндийн төв | 252 | 14.00 | 1778 | 2 | 7 | 5 | 2 | 9 | 1 |
| | Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төв | 240 | 7.00 | 2770 | 2 | 11 | 9 | 2 | 13 | 2 |
| СЭМТ В ангилал /Аймгийн төвөөс 100 км-ээс хол, 2 цагаас дээш хугацаанд зорчих/ | Их-Уул сум дундын эмнэлэг | 112 | 4.00 | 4047 | 2 | 16 | 13 | 3 | 18 | 3 |
| | Улаан-Уул сум дундын эмнэлэг | 164 | 8.00 | 4210 | 2 | 16 | 13 | 3 | 18 | 3 |
| | Цагаан –Уул с сум дундын эмнэлэг | 131 | 5.00 | 5347 | 2 | 15 | 12 | 3 | 17 | 3 |
| | Шинэ-Идэр сум дундын эмнэлэг | 123 | 6.00 | 3218 | 2 | 16 | 13 | 3 | 18 | 3 |
| | Хатгал сум дундын эмнэлэг | 101 | 3.00 | 2998 | 2 | 13 | 10 | 3 | 15 | 3 |
| Нийт дүн | | | | | 46 | 293 | 236 | 57 | 339 | 55 |

Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны
12 дугаар сарын 03-ны өдрийн А/97
дугаар тушаалын 2 дугаар хавсралт

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨВИЙН ХЭМЖЭЭНД 2020-2021 ОНД АШИГЛАГДАХ ЭМНЭЛГИЙН ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

| Эрүүл мэндийн байгууллагын нэрс | | Өдрийн эмчилгээний ор | Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний ор | | | | | | | | | | | Нийт орны дээд хязгаар | Эхчүүдийн амрах байрны орны тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эмнэл зүйн эрт үеийн эмнэлгийн цогц тусламж, үйлчилгээний ор | Үүнээс | | | Өвчнийудаанявц, архагуеийндагнасантусламж, үйлчилгээнийор | Үүнээс | | | | | Сэтгэцийн ор | | |
| | | | | Өвчний хурц /цочмог/ үеийн ор | Өвчний хурцавтар /цочмогдуу/ үеийн ор | Сурьеэгийн ор | | Уламжлалтын ор | Сувилахуйн ор | Хөнгөвчлөх асаргаа сувилгааны ор | Сэргээн засахын ор | Сувиллын ор | | | |
| Аймгийн Нэгдсэн эмнэлэг | | 17 | 265 | 220 | 24 | 21 | 70 | 14 | | 28 | | | 28 | 352 | 8 |
| Өрхийн эрүүл мэндийн төв | Дэлгэрмөрөн | 11 | 0 | | | | 0 | | | | | | | 11 | |
| | Далай-Элбэрэлт | 12 | 0 | | | | 0 | | | | | | | 12 | |
| | Энэрэл | 11 | 0 | | | | 0 | | | | | | | 11 | |
| | Энх-Үйлс | 7 | 0 | | | | 0 | | | | | | | 7 | |
| | Гурвангал | 7 | 0 | | | | 0 | | | | | | | 7 | |
| Хувийн хэвшлийн | Энх-Үрс | | 30 | 20 | 10 | | 0 | | | | | | | 30 | |
| | Жаргалан | | 24 | 16 | 8 | | 0 | | | | | | | 24 | |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| эрүүл мэндийн байгууллага | Ренчинжугнай | | 28 | 23 | 5 | | 0 | | | | | | | 28 | |
| | Цээнэ | | 13 | 7 | 6 | | 9 | 9 | | | | | | 22 | |
| | Олондтуслах | | 10 | 7 | 3 | | 10 | 10 | | | | | | 20 | |
| | Отоснамнан | | 20 | 12 | 8 | | 0 | | | | | | | 20 | |
| | Мөнхтулгуур | | 25 | 17 | 8 | | 0 | | | | | | | 25 | |
| | Гуа Мөрөн | | 16 | 10 | 6 | | 0 | | | | | | | 16 | |
| | Циркон | | 8 | 3 | 5 | | 0 | | | | | | | 8 | |
| | Оюун-Ундараа | | 24 | 14 | 10 | | 0 | | | | | | | 24 | |
| | Хүмүүн | | 20 | 14 | 6 | | 0 | | | | | | | 20 | |
| Галтын Халуун усны рашаан сувилал | | | 0 | | | | 130 | | | | | 130 | | 130 | |
| Нөөцийн ор | | | 88 | 54 | 34 | | 128 | 23 | 55 | | 50 | | | 216 | |
| Аймгийн төвийн дүн | | 65 | 571 | 417 | 133 | 21 | 347 | 56 | 55 | 28 | 50 | 130 | 28 | 983 | 8 |